



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2022/03/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ДӨРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000 Дорноговьн Хэрлэн сум Түрэн
УТТ-ын II байр Утас/Факс: 7058-4200

2022.02.11 № 35
танай _____ -ны № _____ -т

Г БАЯН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХҮРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020789

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1.3	1.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4.9	3.7
	Нийт хөрөнгийн дүн	6.2	5.0
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6.2	5.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6.2	5.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	308.5	64.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	308.3	66.6
	Үйл ажиллагааны үр дүн	0.2	(2.1)
	Үйл ажиллагааны бус үр дүн	10.0	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(9.8)	(2.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6.0	6.2
	Тайлант оны үр дүн	0.2	(1.2)
	Эцсийн үлдэгдэл	6.2	5.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	308.5	65.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	308.5	65.5
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	308.5	65.5
	Урсгал зардал	308.5	65.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	308.5	65.5
	Улсын төсвөөс санхүүжих	308.5	65.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь нутгийн өрөө удирдах байгууллагын хувьд орон нутгийнхаа онцлогийг харгалзан нутгаа хөгжүүлэх, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, тохижилт, соёлжилтыг сайжруулах иргэдийнхээ ая тухтай амьдралыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэх.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Баян-Уул сумын ИТХ нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар бараа материалын үлдэгдлийн 1.3 сая төгрөгийн тайланг СС-ын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу бэлтгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	1.3	-	-	-	-	1	1.3	-	-
	НИЙТ	1	1.3	-	-	-	-	1	1.3	-	-

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-Уул сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийн 1.3 сая төгрөгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тайланг "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу бэлтгэх, биелэлтийг 2022 оны 05 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Уул сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Г.Түмэнжаргал, нягтлан бодогч Н.Тунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ